## Брокерыг сонгох

Брокер, дилерийн компани* нь хөрөнгө оруулагч, харилцагчдад үйлчилгээ үзүүлэхэд Санхүүгийн зохицуулах хороноос олгосон тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн биржийн гишүүн байгууллага байх шаардлагатай.

Та өөрийн брокерыг сонгоход дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

***Байршил*** нь таны оршин байх газар/аймаг/сумаанд ойр байх нь тухайн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цаг хугацаг хэмнэх юм.

***Шимтгэл:*** Брокер нь танд үзүүлэх үйлчилгээнд буюу хувьцаа зарах болон авахад нийт үнийн дүнгээс хувь тооцон шимтгэл авах тул уг шимтгэлийн хэмжээг та урьдчилан мэдэх шаардлагатай.

***Харилцагч банк*** /төлбөр гүйцэтгэгч банк/ Брокер нь төлбөр гүйцэтгэгч банкны харилцагч бөгөөд Та мөн өөрийн брокерын банкны харилцагч байх шаардлагатай.

***Үйлчилгээний чанар:*** Брокер нь танд санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хувьд хувьцааны талаарх тодорхой мэдээлэл болон зөвлөгөөг бүрэн өгөх, мэргэжлийн өндөр ёс зүйтэй ажиллах шаардлагатай.

***Туршлага:*** Та өөрийн харилцагч брокерыг сонгохдоо уг компаний туршлага, үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан хугацаа болон харилцагчийн өмч хөрөнгийг үрэлгүйлэхэн, тэдгээрт хохироосон, алдагдалд оруулж байсан эсэхийг анхаарах нь чухал юм.

**Санхүүгийн зохицуулах хороноос олгосон тусгай зөвшөөрөлтэй брокер, дилерийн мэдээлэлтэй танилцах, байршил болон бусад дэлгэрэнгүй мэдээлэлийг www.fsc.mn, www.mse.mn хаягаас авах боломжтой.*

***Энэхүү гарын авлагаас та:***

-ХОЗЭБ /Ягаан, цэнхэр тасалбар/

-Хувьцаа

-Брокер

-Хөрөнгийн биржийн

-ҮЦТГТХТөв

-Хувьцаа эзэмшигчийн нийтлэг эрхэлсэн

талаарх товч мэдээллийг авах болно.


САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Баянзүрх 3
Энхтайвны гөлөгөн IV байр 210644
Улаанбаатар, Монгол Улс

Утас: 51-261657, 51-261659, 70117097
Факс: 329084, 7011-7047
www.fsc.gov.mn

LUX DEV
Luxembourg Agency for Development Cooperation

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЧАДВАРЖИЛТ БҮХИЙ ГЭРЭЭ СУРГАЛТЫН ТӨСӨЛ

Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Баянзүрх 3
"Жи Мобайл" оффис центр 302 тоот
210644 Улаанбаатар, Монгол Улс

Утас: 70127047
www.luxdev.lu


Санхүүгийн зохицуулах хороо
2015 он

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

*Оюуны - Оюунлаг*

# ИРГЭН ТА – ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

## Гарын авлага

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улс дахь *Үнэт Цаасны Зах Зээлийн* үүсэх, хөгжил нь торгох иргэдийн хувийн өмчийг хуулж эзэмшүүлэх түүнийг дэмжих эдийгээр төрийн өмчит нийт 475 үйлдвэрийн газрыг нийт иргэдэд хувьчлсанаар бий болсон түүхтэй. Энэхүү хувьчлалын ажлыг хэрэгжүүлэхдээ тухайн үйлдвэрийн гаргуудыг *Хувьцаат Компани* болгон зохион байгуулж тэдгээрийн хувьцааг худалдан авахад зориулж иргэн нэг бүрт *Хөрөнгө Оруулагчдын Эрхийн Бичиг* /цаашид "ХОЭБ" гэх/-ийг үнэ төлбөргүй олгосон. Хувьчлалыг их, бага хувьчлалын замаар зохион байгуулсан бөгөөд бага хувьчлалд оролцох 3000 төгрөгийн үнэлгээтэй *ХОЭБ /Жижиг Тасалбар/*, их хувьчлалд оролцох 7000 төгрөгийн үнэлгээтэй *ХОЭБ /Дундаж Тасалбар/*-ээр иргэд өөрийн хүссэн хувьцаат компанийн хувьцааг *Брокерын Пүүсээр* зуучлуулан худалдан авсанаар *Иргэн Та Хувьцаа Эзэмшигч* болсон юм.

Үнэт цаасны зах зээлийн үндсэн оролцогчид нь: Хувьцаа эзэмшигч /иргэн та/, хувьцаат компани, брокер байх бөгөөд "Монголын хөрөнгийн биржээ" ТӨХК нь үнэт цаасны арилжаа эрхлэх, "Үнэт цаасны төлбөр тооцоо тооцоолох хадгаламжийн төв" ХХК нь үнэт цаасны хадгалалтын үйлчилгээ үзүүлэх, Санхүүгийн зохицуулах хороо нь хөрөнгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын чиг үүргээгээр оролцогч юм.

Энэхүү зах зээл оролцогч хөрөнгө оруулагч нь өөрийн эзэмшлийн хувьцаанд дүйцэх мөнгөн ашиг авах, эсвэл хувьцаагаа хөрөнгийн биржээ дээр арилжсанаар хувьцааны үнийн өсөлт, бууралтаас хамаарч ашиг олох, мөн эрсдэл хүлээх боломжтой байдаг.

Хувьцаа эзэмшигч та өөрийн эзэмшлийн хувьцааны талаарх мэдээлэл, аль компани хэдэн онд мөнгөн тараасан эрхэм бусад холбогдох мэдээллийг "ҮЦТТХТ" ХХК, "Монголын хөрөнгийн биржээ" ТӨХК болон өөрийн брокерын компаниас гүйцэтгэсэн байдлаар мэдэх боломжтой.

***Хувьцаа*** гэдэг нь компаний хөрөнгө оруулсанаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, мөнгөн ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг хуваалцах болсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад *Эрхийг гэрчилсэн үнэт цаас* юм.

***Брокер*** нь таньд үнэт цаасны зах зээлийн талаарх шаардлагатай мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөө өгөх, үнэт цаасны данс нээх, арилжааны оролцоход зуучлах зэрэг үйлсэн үйл ажиллагаа эрхэлдэг. Иргэн та брокероо сонгоход анхаарах зүйлсийн талаар дараах хуудсаас үзнэ үү.

***Монголын Хөрөнгийн Биржээ*** нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага бөгөөд өөрийн брокероор зуучлуулан үнэт цаасны арилжааны оролцох боломж таньд үргэлж нээлттэй. Аливаа компанийн хувьцааны үнэ хариуцан адилхан бөгөөд хувьцааны зах зээлийн хяналт нь тогтмол өөрчлөгдөн хэвлэлийн тул ханшийн уналтаас та алдагдал хүлээх эрсдэлтэй ямагт анхаарна уу! Хувьцааны зах зээлийн үнэ нь тухайн компанийн өнөөгийн болон цаашдын үйл ажиллагааны ашиг, алдагдал, удирдлага болон засаглалтай холбоотойгоор үүсэх эрлэг нийлүүлэлтээс шалтгаалан өсөх, буурах боломжтой.

***Санхүүгийн Зохицуулах Хороо*** нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм. Таны хөрөнгө оруулж хувьцааг нь эзэмшсэн компанийн үйл ажиллага, хуулиар олгогдсон эрх зөрчигдөх болон брокерийн компанитай холбоотой асуудлаарх өгөгдөл, гомдлыг тус байгууллагад гаргах шийдвэрлүүлэх боломжтой.

## ИРГЭН ТА Хувьцаа эзэмшигч!!!

**"ҮЦ ТТТХТ" ХХК** нь брокероор зуучлуулан нэгдсэн таны үнэт цаасны юрийн данснд таны хувьцааг хадгалах, хувьцааны бүртгэлтэй холбоотой мэдээлэл өгөх болон компанийн мөнгөн ашиг тараахад зуучлах үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм. Энэхүү байгууллагаас та өөрийн эзэмшлийн хувьцааны талаарх мэдээллийг авах боломжтой.

***Хувьцаат Компани /ХК/*** буюу үнэт цаас гаргагч компани нь өөрийн тусгайсан эд хөрөнгөтэй, тухайн хөрөнгө нь тодорхой тооны хувьцааны хуваалцах буюу олон нийтийн өмчлөл бүхий, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээд юм.

***Хувьцаа Эзэмшигч Та*** дараах нийтлэг эрхтэй. Үүнд:

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөөс өөрийн эзэмшдэг хувьцаатай дүйцэх хэмжээний хувийг эзэмших;

2. Нөгөөл ашиг авах;

3. Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, хуралаар хэлэлцэж буй бүх асуудлаар санал өгөх;

4. Компанийн удирдлагыг сонгоход оролцож;

5. Хувьцаа нь эзэмшиж буй компанид хяналт тавих;

6. Хувьцаа нь эзэмшиж буй хувьцаат компаниас нэмж үнэт цаас гаргасан тохиолдолд өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн эзлэхийг худалдан авах;

7. Компанийн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн үр дүнгийн талаар мэдээлэл авах;

8. Таны хуулиар олгогдсон эрхийг хязгаарласан шийдвэр гаргасан болон Компанийн тухай хуульд заасан зарим тохиолдлуудад өөрийн эзэмшиж буй үнэт цаасаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;

9. Компанийг татан буулгах үед тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх